



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/368

Есенбунар сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 17 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль, тогтоомж, Засгийн газрын болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах ажлыг "Мэдээллийн гүүр" НҮТББ-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т олгосугай.

2. Гэрээний зардалд шаардагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулан ажлыг чанартай гүйцэтгүүлэн тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Хэвлэлийн алба (Д.Баяраа)-д үүрэг болгосугай.

4. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж хамтарч ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг), Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

